



ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ  
СОНИРХОГЧДОД

**АВТО ТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ  
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР**

Чингисийн өргөн чөлөө 200/6, 3 дугаар хороо,  
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17061  
Утас/Факс: (976) 7012 7042

2024.07.22 № 1/771  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Тендер хүчингүй болгох тухай**

Тус үйлдвэрийн газрын 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд Өмнөговь аймгийн Цогтцэций суманд тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн байр шинээр барих ажил тусгагдсан бөгөөд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарлаж 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдөр нээсэн.

Энэхүү тендерт нийт 2 оролцогч буюу Тэлмүүн доной ХХК, Төгс баялаг алтай ХХК нар оролцсон хэдий ч хянан үзэх шатанд тэнцээгүй тул татгалзсан тухай мэдэгдэл тус тус хүргүүлж тухайн тендерийг 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдөр дахин зарласан.

Тендерт оролцогч Тэлмүүн доной ХХК нь тендерийн сонгон шалгаруулалтын үр дүнг үл зөвшөөрч Сангийн яаманд гомдол гарсан бөгөөд тус яамнаас 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 03/5145 дугаартай албан бичгээр тендер шалгаруулалтыг түдгэлзүүлж, 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 03/5543 дугаартай албан бичгээр гомдол үндэслэлтэй тул тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийхийг мэдэгдсэн.

Үнэлгээний хороо Сангийн яамнаас гомдол хянасан тухай албан мэдэгдэлтэй танилцаж ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах хурлыг дахин хийж зөвлөмжийг захиалагчид хүргүүлсний дагуу захиалагчийн зүгээс Тэлмүүн доной ХХК-д гэрээ байгуулах эрх олгосон.

Иймд цахим системээр 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдөр зарлаж өөрчлөлтийн хүсэлт гаргасан АТҮТ/20240101024/03/01 дугаартай Өмнөговь аймгийн Цогтцэций суманд тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн байр шинээр барих ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг дахин зарлахгүй тул хүчингүй болсныг мэдэгдэж байна.

ЗАХИРАЛ



Б.ГҮРСОРОНЗОН

000000719